

## **“СОЁЛЫН САЛБАР ДАХЬ ЖЕНДЭРИЙН АСУУДАЛ”** сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын удирдамж

### **Оршил**

Соёлын яам, Жендэрийн үндэсний хороо хамтран жендэрийн эрх тэгш байдлыг хангах хуулийг хэрэгжүүлэхэд соёлын салбарын оролцоо, дэмжлэг нэн хэрэгцээтэй байгаад үндэслэн, өнөөгийн нийгмийн оюун санаа, ёс суртахууны төлөвшил, жендэрийн хэвшмэл ойлголт хандлагыг өөрчлөхөд соёлын салбарын оролцоог нэмэгдүүлэх, салбарын бодлого, хөтөлбөр, үйл ажиллагааны жендэрийн мэдрэмжтэй байдлыг нэмэгдүүлэх, салбарт баримтлах жендэрийн чиг хандлагыг тодорхойлох зорилгоор **“СОЁЛЫН САЛБАР ДАХЬ ЖЕНДЭРИЙН АСУУДАЛ”** сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг 2022 оны 10-р сарын 10-ны өдөр зохион байгуулах юм.

Соёлын салбарын жендэрийн асуудлыг хөндөх энэхүү эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулснаар Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Соёлын тухай хууль болон Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг “Алсын хараа-2050”, Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилт зэрэг холбогдох бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг эрчимжүүлэхэд салбарынхан мэдлэг, туршлагаа хуваалцан хөгжүүлэх, соёлын салбарын бодлого, хөтөлбөр, үйл ажиллагааны жендэрийн мэдрэмжтэй байдлыг дээшлүүлэх, салбарт баримтлах жендэрийн бодлогыг оновчтой тодорхойлоход хувь нэмэр оруулах юм. Түүнчлэн соёлын салбарт жендэрийн эрх тэгш байдлыг хангахтай холбоотой асуудлуудыг цаашид гүнзгийрүүлэн судлах эхлэл тавигдаж, мэдээлэл солилцох боломжоор хангагдахын зэрэгцээ жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаарх ойлголтыг соёлын бүтээлч үйлдвэрлэлийн хөгжлийн үйл явцтай уялдуулах, хөгжлийн үйл явцад саад болж буй жендэрийн хэвшмэл ойлголт хандлагыг өөрчлөх арга хэмжээг соёл, урлагийн салбарын бодлого, хөтөлбөр, үйл ажиллагаа болон соёлын салбарын бүхий л байгууллага, тэдгээрийн үйл ажиллагаагаар дамжуулан эрэгтэй, эмэгтэй хүмүүс, охид, хөвгүүдэд түгээн дэлгэрүүлэхэд хувь нэмэр үзүүлнэ.

Тус эрдэм шинжилгээний бага хурлын бэлтгэл ажлын хүрээнд Монгол Улсын соёлын салбарт тулгамдаж буй жендэрийн асуудал, түүнийг шийдэх шийдлийн талаарх олон ургалч үзэл бодол, санаа, боломж, шийдлийг харуулах зорилгын дор салбарын эрдэмтэн, судлаачид, ажиллагчдын хүрээнд “Соёл ба Жендэр” сэдэвт илтгэлийн уралдааныг зарлаж, дүгнэн шалгарсан бүтээлүүдийг эрдэм шинжилгээний бага хурлын үеэр танилцуулж, дэвшүүлсэн санал, хөгжлийн гарцуудын талаар хэлэлцэн, зөвлөмж гаргана.

Салбарын эрдэмтэн, судлаачид, ажиллагчдын хүрээнд зарлаж буй энэхүү илтгэлийн уралдаанаас хүлээгдэж буй гол үр дүн:

1. Соёлын салбар дахь жендэрийн эрх тэгш байдлыг харуулсан жендэрийн статистик болон хүйсээр ангилсан тоон мэдээлэлд жендэрийн дүн шинжилгээ хийх

2. Салбарын бодлого, эрх зүйн орчин, мэргэжлийн холбоодын үйл ажиллагаанд тулгамдаж буй жендэрийн асуудлыг тодорхойлох
3. Олон улсын түвшинд соёлын салбарт баримтлаж буй жендэрийн тэгш байдлыг хангасан сайн туршлага, хандлагыг нэвтрүүлэх
4. Олон нийтийн соёлын боловсрол дахь жендэрийн агуулгын хэрэгцээг тодруулах

#### **Хамрах хүрээ:**

Соёлын салбарын эрдэмтэн, судлаачид, ажиллагчид оролцоно.

#### **Илтгэлийн сэдвийн хамрах хүрээ, агуулга:**

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангах, нийгмийн харилцаанд эрэгтэй эмэгтэй хүмүүст адил тэгш боломжийг бүрдүүлэхэд нийгмийн ойлголт хандлагыг эерэг болгох, нийгэмд тогтсон жендэрийн хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд соёлын салбарын оролцоог нэмэгдүүлэх, жендэрийн тэгш байдлыг хангах бодит үйл ажиллагааны шийдэл бүхий агуулгатай байна. Үүнд:

- Соёлын салбарын бодлогыг жендэрийн мэдрэмжтэй болгох нь
- Соёлын салбарт ажиллагчдын хүйсээр ангилсан мэдээлэлд жендэрийн дүн шинжилгээ хийх нь
- Соёлын бүтээлч үйлдвэрлэл ба Жендэр ба хөгжил хандлага
- Олон улсад соёлын салбарт баримталж буй жендэрийн тэгш байдлыг хангасан сайн туршлага г.м

#### **Илтгэлийн агуулгад тавигдах шаардлага:**

- Эрдэм шинжилгээний бага хурлын зорилготой уялдсан байх
- Судалгаа, нотолгоонд суурилсан байх
- Хэрэгжүүлэхүйц, шинэлэг санаа дэвшүүлсэн байх
- Бодит мэдээлэл ашиглаж, баримт материал хавсаргасан байх
- Ашигласан ном, материалын жагсаалт бичиж, ерөнхий дүгнэлт, зөвлөмжтэй байх
- Илтгэлийн хураангуйг боловсруулсан байх
- Хуралд ирүүлсэн илтгэлийг оролцогчдод буцаан олгохгүй бөгөөд зохион байгуулагч тал иш татах зэргээр ашиглахыг зөвшөөрсөн байх

#### **Илтгэлийн бүтцэд тавигдах нийтлэг шаардлага:**

- Илтгэлийн нэр
- Үндэслэл, зорилго, ач холбогдол
- Онол арга зүйн үндэс, аргачлал
- Дүгнэлт, санал, зөвлөмж
- Ашигласан материалын жагсаалт
- Зохиогчийн овог нэр, нас, хүйс, ажил мэргэжил, зэрэг дэв
- Илтгэлийн хураангуй /абстракт/ түлхүүр үгсийн хамт 250-260 үгт багтсан байх
- Дэлгэрэнгүй илтгэл 10-12 нүүрт багтсан байх

#### **Илтгэлийн бичвэрт тавигдах шаардлага**

- Үсгийн фонд Arial, хэмжээ 12, мөр хоорондын зай 1.5, цаасны хэмжээ A4, хуудас 10-12, хэл- Монгол

- Илтгэл нь ишлэл, зүүлт бичих шаардлагыг хангасан байна.
- Ишлэл болон ашигласан материал нь зохиогч, зохиогчийн овог, бүтээлийн нэр, хэвлэсэн газар, он, хуудас гэсэн дараалалтай байна.

**Илтгэгчдэд тавигдах шаардлага:**

Илтгэлийг ирүүлэхдээ бүрэн илтгэл 1 хувь, хураангуй илтгэл 1 хувийг тус тус хэвлэж ирүүлсэн байх, танилцуулгыг MS Power Point дээр, 10 минутанд багтаан танилцуулахаар бэлтгэх, 4х6 харьцаатай 1 хувь цээж зураг, холбоо барих утасны дугаар, и-мэйл хаяг зэрэг мэдээллүүдийг бичсэн байна.

**Илтгэл хүлээн авах эцсийн хугацаа:** Илтгэлийг 2022 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн 08.30-17.30 цагт ЖҮХ-нд гэж хаяглан ирүүлнэ.

Цахим хаяг: [narantsatsral@ncge.gov.mn](mailto:narantsatsral@ncge.gov.mn)

Холбогдох утас: 700711115, 99991523

**Шүүгчид:** СЯ, ЖҮХАА, жендэрийн зөвлөх, жендэрийн үндэсний шинжээчдийн төлөөлөл бүхий нийт 5 шүүгч ажиллана.

**Шалгаруулалт:** Эрдэм шинжилгээний бага хуралд ирүүлэх илтгэлийн шалгаруулалт 2 үе шаттай, онооны системээр сонгон шалгаруулах журмаар явагдана.

**1 дүгээр үе шатны сонгон шалгаруулалт: 2022 оны 9-р сарын 26**

Илтгэлийг 5 гишүүнээс бүрдсэн шүүгчдийн баг удирдамжид тусгасан шалгуурын дагуу тус бүр оноо өгч, илтгэлүүдийг хэлэлцэж, дараагийн шатанд оролцох 9 илтгэгчдийг сонгон шалгаруулна.

**2 дугаар үе шатны сонгон шалгаруулалт: 2022 оны 10-р сарын 10**

**Урамшуулал:**

№	Байр	шагнал /төгрөг/
1	Нэгдүгээр байр: нэг мөнгөн шагнал, өргөмжлөл	1,000,000
2	Хоёрдугаар байр: нэг мөнгөн шагнал, өргөмжлөл	700,000
3	Гуравдугаар байр: хоёр, мөнгөн шагнал, өргөмжлөл	500,000
	Нийт шагналын сан:	2,200,000
4	Тусгай байр: үзвэр үзэх эрх	Улсын Драмын эрдмийн театрт 5 удаагийн урлагийн тоглолт, үзвэр үзэх эрх
5	Тусгай байр: үзвэр үзэх эрх	Монголын Үндэсний музейд үзвэр үзэх эрх

**“СОЁЛЫН САЛБАР ДАХЬ ЖЕНДЭРИЙН АСУУДАЛ”** сэдэвт бага хурал 2022 оны 10-р сарын 10-ны өдрийн 10.00 цагт ..... танхимд олон нийтэд нээлттэйгээр болно. Уг хуралд шалгарсан 9 илтгэлийг сонсож, шалгаруулна. Эрдэм шинжилгээний бага хуралд ирүүлсэн шилдэг илтгэлүүдийг “Жендэр судлал” сэтгүүлд хэвлэн, олон нийтэд хүргэнэ. Оролцогчдод эрдэм шинжилгээний хурлын хөтөлбөрийг и-мэйл хаягаар хүргүүлж, утсаар мэдэгдэнэ.